



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 166

Улаанбаатар хот

“Замын-Үүдийн дулааны станц”
төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн
засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон
Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний
биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирал О.Төмөрхуягтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захирал О.Төмөрхуягтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132061306

11-r huraldaan.docx